



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/154

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 02 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 02 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Инженерийн шугам сүлжээ, халаалтын зуухны өргөтгөл /Баян-Адарга сум/" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Баян-Адарга сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, цахим системийн худалдан авах төлөвлөгөөний хугацааны дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Баян-Адарга сумын Засаг дарга /О.Лхагвадорж/-д даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /Л.Батсайхан/, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010421

03 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын 24 өдрийн ... /154
дугаар захирамжийн хавсралт



Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2021 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЭЗ
		Эхлэх	Дуусах			
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан						
1	Инженерийн шугам сүлжээ, халаалтын зуухны өргөтгөл /Баян-Адарга сум/ Нийт дүн	2021	2021	121,216.1	121,216.1	Баян-Адарга сумын Засаг дарга